



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

“Есөн дэлбээ” ХЗХ-ны хадгаламж,
зээлийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Есөн дэлбээ” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгасан талаарх тэмдэглэгээг 2013 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор хийлгэхийг “Есөн дэлбээ” ХЗХ /М.Гантулга/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000351